



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/691

Булган сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.2, 17.2.9 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Бямбажаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Отгонжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн нэгжийн дарга)
Б.Очирбат (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой хариуцсан мэргэжилтэн)
Тухайн сумдыг хариуцсан Сум дундын Ойн ангийн дарга
Тухайн сумын Засаг даргын орлогч
Сумын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч нар
Сумын Байгаль хамгаалагч нар

Нарийн бичгийн дарга: Сум дундын ойн ангийн инженер, техникч

2. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг зохих хууль, журмын дагуу хүлээн авч, улсын комисст хүлээлгэн өгч ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай.

3. Аймаг, сумын комиссын хүлээж авсан ойжуулалт, нөхөн сэргээлтийн талбайд мал бэлчээхгүй, өвөлжөө, хаваржааны газар олгож хадлан хадлуулахгүй байх, амьдралтын хувьд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/576 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ